

6 дугаар хэсгээр

ГҮЙЦЭТГЭГЧ Г.ГАНЗОРИГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Нэг. I үнцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1.4 “Гаалийн байгууллагын дэд бүтэц чадавхийг бэхжүүлэх”							
	Хар тамхитай тэмцэх чиглэл: 1. Тайлант хугацаанд хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан 13 удаагийн үйлдлийг таслан зогсоож, эзэн холбогдогч болон нотлох баримтын хамт эрх бүхий байгууллагуудад харьяаллын дагуу шилжүүлэн өгөхтэй холбоотой зөвлөмж, чиглэлээр харьяа гаалийн газар, хороодын ханган ажилласан. Дээрх зөрчлөөс дурдвал: 1. [redacted] – 8 [redacted] буюу 24 мл (УХШИГТ) /УХШИГТ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар [redacted] хамтран ажиллаж,						
1.	Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, бэлэн мөнгө /валют/-ийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдамжаар хангасан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	80%	50%		2025.01.01-2025.06.10	100

				илгээмж хүлээн авагчийг [REDACTED] компанийн байрнаас дайчлан баривчилсан./ 2. [REDACTED] – 89.11 грамм (ЧХОУНБГТ) / [REDACTED] ирүүлсэн мэдээллийн дагуу тус байгууллагын алба хаагчидтай хамтран [REDACTED] чиглэлийн нислэгээр зорчин ирсэн зорчигчийн гар тээш, дагалдах ачаанд хяналт шалгалт явуулахад тухайн зорчигчийн дагалдах ачаанаас [REDACTED] утсанд нуун далдлагсан 89.11 грамм [REDACTED] илрүүлсэн бөгөөд [REDACTED] байгууллагад хүлээлгэн өгсөн./ 3. [REDACTED] – 33 грамм (ЧХОУНБГТ) /Гаалийн автоматжуулсан удирдлагын систем [REDACTED] ирсэн [REDACTED] чиглэлийн нислэгээр зорчин ирсэн бөгөөд тухайн иргэнийг нягтлан шалгах чиглэлийг ЧХОУНБГТ-ын Зөрчилтэй тэмцэх албанд өгсөн. Хяналт шалгалтын ажиллагааг явуулахад тус иргэний гар тээшнээс [REDACTED] илэрсэн ба харьяаллын дагуу [REDACTED] байгууллагад хүлээлгэн өгсөн./ 4. [REDACTED] – 200 ширхэг (ЧХОУНБГТ) /ЧХОУНБГТ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас [REDACTED] ирсэн зорчигчийн ачаанаас үл мэдэгдэх эм гарч ирлээ гэсэн мэдээллийн дагуу нягтлан шалгахад Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенцийн дөрөвдүгээр хавсралтад багтсан [REDACTED] гэх бодис байсан тул харьяаллын дагуу [REDACTED] байгууллагад хүлээлгэн өгсөн./ 5. [REDACTED] – 12 [REDACTED] буюу 36 мл (УХШИГТ) /УХШИГТ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн [REDACTED]
--	--	--	--	--

				байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг [redacted] компанийн байрнаас дайчлан баривчилсан./ 6. [redacted] – 7 шилэн [redacted] 21 мл (УХШИГТ) /УХШИГТ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн илгээмжийг [redacted] илгээмж хүлээн авагчийг [redacted] байгууллагатай хамтран ажиллаж, [redacted] илгээмж хүлээн авагчийг [redacted] дайчлан баривчилсан./ 7. [redacted] – 5 мл (УХШИГТ) /УХШИГТ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн [redacted] байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг [redacted] дайчлан баривчилсан./ 8. [redacted] – 100 грамм (УХШИГТ) /УХШИГТ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн [redacted] хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг [redacted] баривчилсан./ 9. [redacted] – 840 грамм (УХШИГТ) /УХШИГТ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн
--	--	--	--	---

					илгээмжид дүн шинжилгээ хүйхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг дайчлан баривчилсан./ 10. _____ – 510 грамм (ЧХОУНБГТ) _____ хяналт, шалгалтын арга хэмжээг хэрэгжүүлж _____ дамжин ирсэн зөрчилчийн дагалдах ачааг рентген төхөөрөмжөөр оруулан шалгахад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул _____ 11. _____ – 0.39 грамм (ЧХОУНБГТ) _____ байгууллагаас ирүүлсэн мэдээллийн дагуу тус байгууллагын алба хаагчидтай хамтран _____ чиглэлийн нислэгээр зорчин ирсэн зорчигчийн гар тээш, дөгалдах ачаанд хяналт шалгалт явуулахад тухайн зорчигчийн гар тээшнээс 0.39 грамм _____ гэх бодисыг илрүүлсэн бөгөөд _____ байгууллагад хүлээлгэн өгсөн./ 12. _____ – 250 мл (УХШИГТ) /УХШИГТ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хүйхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн _____ _____ илгээмж хүлээн авагчийг _____ баривчилсан./
--	--	--	--	--	---

				13. [REDACTED] – 180 грамм (УХШИГТ) /УХШИГТ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн [REDACTED] байгууллагуудтай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг [REDACTED] <u>Үр дүн:</u> Хэрэг, зөрчил илрүүлэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 55 хувиар өссөн үзүүлэлттэй байна. <u>Мөнгө угаахтай тэмцэх чиглэл:</u> Тайлант хугацаанд Бэлэн мөнгө (валют)-тай холбоотой 2 удаагийн зөрчлийн үйлдлийг илрүүлсэн. Үүнд: 1. 2024 оны [REDACTED] дугаар сарын [REDACTED] өдөр [REDACTED] доллар буюу [REDACTED] сая төгрөгтэй тэмцэх хэмжээний валютыг)-ийг гаальд мэдүүлэхгүйгээр улсын хилээр авч орохыг завдсан зөрчлийг илрүүлж гаалийн байгууллагад мэдүүлээгүй зөрчилд холбогдсон бараа болох [REDACTED] улсын орногод хурааж, [REDACTED] төгрөгийн торгууль ногдуулж шийдвэрлэсэн. 2. 2025 оны [REDACTED] буюу [REDACTED] төгрөгтэй ын иргэн [REDACTED] валют)-ийг гаальд тэнцэх хэмжээний валют)-ийг гаальд мэдүүлэхгүйгээр улсын хилээр авч орохыг завдсан зөрчлийг илрүүлж, [REDACTED] төгрөгөөр торбож, хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн.
--	--	--	--	---

					- Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 9-ний өдрийн А/04 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-149 дэх ажлын хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх чиглэлээр "Гаалийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн-2025" арга хэмжээний үеэр Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хороод болон зөвлөгөөнд оролцогч нарт улсын хилээр нэвтрэх буй бэлэн мөнгө (валют)-ийн гаалийн хяналт, шалгалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар зөвлөмж, арга зүйн зөвлөгөөг өгсөн. Энэ хүрээнд Гаалийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хуульд заасан 15 сая төгрөгөөс доош хэмжээгээр хилээр нэвтрүүлж буй бэлэн мөнгө (валют)-ийг хилээр нэвтрэх зорчигчид зайлшгүй гаалийн байгууллагад мэдүүлэх үүрэгтэй гэдгийг алба хаагч нар нэг мөр ойглох талаар зөвлөмж, арга зүйгээр хангаж ажиллаж байна. <u>Үр дүн:</u> Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэ төрлийн зөрчил илрүүлэлт 50 хувиар өссөн үзүүлэлттэй байна.		
2.	Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	80%	50%	<u>Хар тамхитай тэмцэх чиглэл:</u> - Гаалийн ерөнхий газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс Тагнуулын ерөнхий газрын [redacted] хооронд 2025 оны [redacted] өдөр байгуулагдсан Хамтран ажиллах удирдамж, төлөвлөгөөний дагуу Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх таслах зогсоох чиглэлд хамтран ажиллаж байна. - Монгол банкнаас 2025 оны [redacted] ний өдрийн [redacted] дугаартай албан ёсчээр	2025.01.01-2025.06.10	100

				Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг /бага дүнтэй/ их хэмжээгээр улсын хилээр гаргаж зориулалтын бусаар ашиглаад байгаа асуудлыг хамтран шийдвэрлэх тухай хүсэлт ирүүлний дагуу Монгол Улсын Валютын зохицуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтад "Монгол Улсын үндэсний валют, чөлөөтэй хөрвөдөггүй гадаад валютыг Монгол Улсын хилээр оруулах, гаргах, валютын гүйлгээнд ашиглах журмыг Монголбанкны ерөнхийлөгч,       гаргахгүй байх хязгаарлалтыг тогтоосугай гэх заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, энэ төрлийн зөрчил илэрсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх гаалийн газар, хороодын дарга нарт талаар чиглэл хүргүүлж хяналт тавьж ажилласан. Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газрын хооронд 2025 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх, таслан зогсоох чиглэлд хамтран ажиллах төлөвлөгөөт 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр батлан, хамтран ажиллаж байна. Гаалийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарын 2025 оны  ны өдөр хамтран баталсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулах  арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд гурван байгууллага хамтран ажиллаж байна. Гаалийн тухай хуулийн 250.1-т "Гаалийн байгууллагаас олон улсын гэрээний, эсхүл бусад улсын гаалийн болон эрх бүхий байгууллагатай	
--	--	--	--	---	--

[illegible]

				хууль сахиулах ажиллагааны цуврал 7 дахь ажиллагааны өмнөх цахим хуралд 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр оролцсон. Бүгд Найрамдах Солонгос Улсын Гаалийн байгууллага болон Зүүн өмнөд азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг "АСЕАН" хамтран Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр [redacted] Олон улсын хууль сахиулах ажиллагааны өмнөх 2025 оны 6 дугаар сарын 24 өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн хуралд оролцохоор төлөвлөж байна. <u>Ур дүн:</u> Тайлант хугацаанд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий Тагнуул, Цагдаагийн байгууллагатай хоёр талт болон гурван байгууллагын хамтран ажиллах төлөвлөгөөг тус тус баталсан. Мөн тайлант хугацаанд илрүүлсэн [redacted] үйлдлийн удаагийн үйлдэл дээр [redacted] хүргэх арга хэрэглэсэн нь [redacted] байна. ОХУ-ын ХГА-ны Сибирийн хууль сахиулан газартай хамтран "Мансууруулах бодисыг гаалийн хяналтын дор хүргэх сургалт-ажиллагаа" зохион байгуулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлснээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хөрш орны гаалийн байгууллагатай хамтран ажиллах боломж бүрдэх, төв азийн улс орнуудаас ирж буй урсгалд хяналт тавих, алба хаагчдад дадлага туршлага хуримтлуулах өндөр ач холбогдолтой юм. <u>Мөнгө угаахтай тэмцэх чиглэл:</u> [redacted] Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны
--	--	--	--	--

				өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 09 дугаартай тушаалаар Үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлтэй барааны хяналтын хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж, гаалийн байгууллагын саналыг тусгуулахаар ажлын хэсгийн шугамаар хүргүүлсэн. - Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, "Монгол шуудан" хувьцаат компанийн хооронд 2024 оны [redacted] сарын [redacted] өдөр байгуулагдсан [redacted] дугаартай Хамтын ажиллагааны Санамж бичгийн хүрээнд ЦЕГ, ГЕГ, Монголшуудан ХК-ийн дарга нарын 2025 оны [redacted] дугаар сарын [redacted] өдрийн [redacted] дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалыг баталж ажиллаж байна. - ФАТФ-аас 2027-2028 онд Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд харилцан үнэлгээ хийхтэй холбоотой "ФАТФ-ын харилцан үнэлгээ болон гаалийн байгууллагын анхаарах асуудлууд" сэдвийн хүрээнд ГЕГ-ын бүтцийн нэгжүүд болон ГЕГ-ны харьяа Гаалийн газар, хороодын нийт алба хаагчдад 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албатай хамтран ГЕГ-ын Мэдээллийн цагаар сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулсан.			
3.	Хар тамхи, мөнгө угаах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	50%	<u>Хар тамхитай тэмцэх чиглэл:</u> - Энэ оны 12 дугаар сард Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтоор орох чиглэлд хил нэвтэрсэн Монгол Улсын иргэдийн бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт шалгалт хийх явцад их хэмжээний буюу 24 нэр төрлийн 1200 орчим хайрцаг эмийг ундаа, жүүсний тетрафак сав, жингэмийн хайрцаг болон биедээ нууж улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан үйлдлийг илрүүлэн холбогдох шалгалтын ажиллагааг явуулж байгаа болон эдгээр эмүүдийн дунд мэдээллийн өвдөлтийн хам шинж, захын мэдээллийн өвдөлтийн	2025.01.01-2025.06.10	100

				үед хэрэглэдэг өвчин намдаах үйлчилгээтэй эмчийн жороор олгодог эм их хэмжээгээр байсан ба энэхүү эмийг тун хэтрүүлэн хэрэглэсэн тохиолдолд мансууруулах үйлчилгээг мөн үзүүлдэг тул урвуулан мансуурах зорилгоор ашиглаж байгаа тул ерөнхий боловсролын сургуулийн дунд ахлах ангийн сурагчид, өсвөр насны хүүхдүүд тус эмийг мансуурах зорилгоор урвуулан хэрэглэснээс болж, гар, хөлийн хуруу эд эрхтэн нь үхжих цаашлаад тайруулах хүртэл эрсдэл үүсэж байгаа талаар анхааруулга мэдээллийг бэлтгэж гаалийн байгууллагын цахим хуудаст нийтлүүлсэн. Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, химийн болон угтвар, тэсрэх бодис анхан шатанд таньж тодорхойлогч [REDACTED] [REDACTED] төхөөрөмжийг хэрхэн оновчтой зөв ашиглах, арчлах тухай цуврал видео сургалтын материалыг бэлтгэж DVD-нд хуулбарлан 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр [REDACTED] дотоод зурвасаар ГЕГ-ын Сургалтын төвд, мөн өдрийн [REDACTED] тоот албан бичгээр харьяа гаалийн 19 газар, хороодод хүргүүлсэн. Мөн Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан ёсны фэйсбүүк группт 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Видео хичээл № 1 ([REDACTED]) -ийг нийтэлсэн бөгөөд 1900 үзэлтэй, 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Видео хичээл № 2 [REDACTED] -ыг нийтэлсэн бөгөөд 721 үзэлтэй байна. ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газартай хамтран тусгай шалгалтад тэнцэж, болзуур шалгуурыг ханган харьяа гаалийн газар, хороодод төрийн тусгай албан тушаалд томилогдох 44 иргэнээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх сорилыг авсан. Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан ёсны фэйсбүүк группт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Сэтгэцэд нөлөөт бодисын тухай	
--	--	--	--	---	--

				1971 оны конвенцын хоёрдугаар хавсралтад багтсан [REDACTED] [REDACTED] [REDACTED] зэрэг бодис агуулсан синтетик болон хатас синтетик шинэ төрлийн хар тамхи болох "Дусал" болон түүнийг халаан ууршуулагч төхөөрөмжийн тухай Сэрэмжлүүлэг №1-ийг нийтэлсэн. Мөн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр [REDACTED] гэх бодис агуулсан төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүнийг хэрхэн таних тухай танилцуулга мэдээллийг нийтэлсэн. Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдөр хамтран багласан "Улс хооронды шуудан илгээмж, карго үйлчилгээ үзүүлэгч иргэн, ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийх уулзалт" зохион байгуулах удирдамжийн дагуу Улс хоорондын шуудан илгээмж, карго үйлчилгээ үзүүлэгч иргэн, аж ахуй нэгжийн төлөөллүүдтэй 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр улс хоорондын шуудан илгээмж ашиглан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшлийн түншлэл сэдвээр уулзалт зохион байгуулсан бөгөөд нийт 50 төлөөлөл уулзалтад оролцсон. Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын гаалийн хяналтын бүсээр 510 грамм мансууруулах бодисыг жигнэмэгийн утанда нуун далаалж улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан үйлдлийг таслан зогсоосон тухай сэрэмжлүүлэг видеог бэлтгэн 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр IEF-ын албан ёсны "Монголын гааль" Фэйсбүүк хуудаст нийтэлсэн бөгөөд 36.7 мянган үзэлттэй байна. Гаалийн байгууллага 2025 оны эхний улиралд хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан 7 удаагийн	
--	--	--	--	--	--

				үйлдлийг илрүүлсэн тухай сэрэмжлүүлэг видеог бэлтгэн 2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр ГЕГ-ын албан ёсны "Монголын гааль" Фэйсбүүк хуудаст нийтэлсэн бөгөөд 18.6 мянган үзэлттэй байна. "Мансууруулах эм, сэтгэцэд, нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан гэмт хэргийн нөхцөл байдал, арга хэлбэр буюу түүнтэй тэмцэх нь", "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг рентген хяналтаар таньж илрүүлэх аргачлал" сэдэвт сургалтыг тусгай шалгалтад тэнцэж, болзол шалгуурыг ханган харьяа гаалийн газар, хороодод төрийн тусгай албанд томилогдох, гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад хамрагдаж буй 44 иргэнд 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр орсон. ГЕГ-ын даргаас өгсөн чиглэлийн дагуу тус нэгжээс 2025 оны эхний 5 сарын байдлаар хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ, дүн шинжилгээнд үндэслэн хэрэгжүүлсэн шалгалт, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн олон улсын болон бус нутаг, дотоодын нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн чиглэлийн талаарх танилцуулга мэдээллийг ГЕГ-ын удирдлага болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй гаалийн газар хороодын удирдлагад яаралтай хаалттай мэдээллийг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр ЗТГ-ын [redacted] хийсэн ба тухайн мэдээллийн бэлтгэл ажлын хүрээнд 23 слайд бүхий танилцуулгыг боловсруулж ажилласан. Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын нийт алба хаагчдад 2025 оны 05 дугаар сарын 08-09-ны өдрүүдэд Улаанбаатар хот дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн газрын нийт алба хаагчдад 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр, Замын-Үүд	
--	--	--	--	---	--

				дэх гаалийн газрын нийт алба хаагчдад 2025 оны 06 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн талаарх бус нутгийн болон дотоодын нөхцөл байдал, анхаарах асуудал" сэдвийн хүрээнд танилцуулга, мэдээлэл хүргэсэн бөгөөд нийт 650 алба хаагч хамрагдсан. Улаанбаатар хот дахь гаалийн газрын дарга, нийт албадын дарга, ГУАБ нарт болон УБТЗ, Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо, Гаалийн хяналтын бус эзэмшигч ААН, Гаалийн зуучлалын мэргэшсэн холбоодын удирдах алба тушаалтнуудад 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн өнөөгийн нөхцөл байдал, анхаарах асуудал" сэдвийн танилцуулга, мэдээлэл хүргэсэн бөгөөд нийт 60 албан тушаалтан хамрагдсан. Чингис хаан олон улсын нисэх буудалд дахь гаалийн газрын хяналт тавьж буй Карго терминалын гаалийн хяналтын бүсэд ашиглаж буй гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжийн ашиглалтыг нэмэгдүүлэх хяналттай байлгах зорилгоор тухай тоног төхөөрөмжийг гаалийн байгууллагын төлөхяналтын нэгдсэн системд холбох ажлыг ШХТ-тэй хамтран шийдвэрлэж хариуг 2025.06.04-ний дотор ирүүлэхийг чиглэл болгосон. Тус чиглэлийн дагуу холболтын ажлыг хийж ашиглалтад оруулсан тухайн хариуг 2025.06.04-ний өдрийн [REDACTED] дугаартай албан бичгээр ирүүлсэн. <u>Үр дүн:</u> Дээрх ажил, арга хэмжээг хэрэгжүүлснээр алба хаагчдад энэ төрлийн хэрэг, зөрчлийн талаар ойлголт өгөх, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх үйлдэл дээр хяналт тавих, мансууруулах бодисыг таньж илрүүлэх чиглэлээр мэдлэг, мэдээлэл олгосноор энэ төрлийн хэрэг,	
--	--	--	--	---	--

зөрчлийн илрүүлэлт нэмэгдсэн. Мөн гаалийн харилцаанд оролцогч иргэн аж, ахуйн нэгжийн төлөөлөлд мэдээлэл хүргэснээр хууль тээвэрлэлт, мэдлэг дутуугаас энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр:

[illegible]

		эхний 3 хичээлийг видео хэлбэрт шилжүүлэн гаалийн байгууллагын алба хаагчдад хүргэсэн. ДТБ-ын Ази, номхон далайн бүс нутгийн байгууллага болох Зөрчлийн мэдээлэл солилцох төв (МСО RLO/AR)-өөс ирүүлсэн бүс нутгийн хэмжээнд илрүүлсэн хориглосон, хязгаарласан бараат хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг заавдсан үйлдэл, бараат гаалийн хяналтаас нуун далдлах арга хэлбэрийн талаарх 25 удаагийн Сэрэмжлүүлэг мэдээллийг тухай бүр орчуулж, сөр дотоод сүлжээнд байршуулсан. <u>Үр дүн:</u> Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ, сургалт, мэдээллийн үр дүнд харьяа гаалийн газар, хороодод илрэх хэрэг зөрчил илрүүлэлт, үр дүн нэмэгдсэн.	
Мэдээллийн санд мөнгө угаах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой дүн шинжилгээ хийсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100% 50%	<u>Хар тамхитай тэмцэх чиглэлээр:</u> Түүвэр /карго/ ачаанд хар тамхи, мансууруулах бодисыг нуувч болгон ашиглаж улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завадаж байж болгошгүй гэж үзэн ЧХОУНБГТ-т [redacted] сүүлийн 1 жилд импортын бүрдүүлэлт хийсэн иргэн, аж ахуй нэгжийн гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үүнд: [redacted] и [redacted] удаагийн гаалийн бүрдүүлэлтээр [redacted] ачаат гаалийн байгууллагад [redacted] төгрөгийн татварыг төлсөн байна. Дээрх дүн шинжилгээнд үндэслэн 2025 оны эхний хагас жилийн байдлаар [redacted] и [redacted] ижийн ачаанд нарийвчилсан үзлэг хийж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг заавдсан [redacted] үйлдлийг илрүүлэн харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлж ажигласан байна. "Гаалийн автоматжуулсан удирдлагын систем [redacted]

тамхи, мансууруулах бодис зөрчлийн төрөлд бүртгэгдсэн иргэдийн мэдээллийг шинэчлэх ажлын төлөвлөгөө"-г 2025 оны 05 дугаар сарын 09-ны өдөр Зөрчилтэй тэмцэх газрын даргаар батлуулсан 2025 оны 06 дугаар сард багтаан тус ажлыг дуусгахаар ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр тус тус тус тус хамтран ажиллах тухай

Европын орнуудаас гарал үүсэлтэй барааны бүрдүүлэлтийн мэдээлэлд дүн шинжилгээт боловсруулж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдолтой хэрэг, зөрчил ихээр бүртгэгддэг эрсдэлтэй улс орноос ирж буй түүвэр, карго ачааны гаалийн бүрдүүлэлт хяналт, шалгалтад тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Ур дүн: ачааны бүрдүүлэлт хяналт, шалгалтад тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр:

- Зорчигчийн гаалийн мэдүүлгээр 2024 онд гаалийн байгууллагад мэдүүлсэн валютын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ хийж, ГЕГ-ын харьяа

				гаалийн газар, хороодод 2025 оны [redacted] дугаар сарын [redacted] өдрийн [redacted]-тоот "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгээр 6 хуудас бүхий бэлэн мөнгө, валютын дүн шинжилгээний мэдээллийг хүргүүлэв. Мөн 2024 оны [redacted] дугаар сарын [redacted] өдрийн [redacted] дугаартай дотоод албан бичгээр ГЕГ-ын Хяналт, бүрдүүлэлтийн газарт хүргүүлсэн. Зорчигчийн гаалийн мэдүүлгээр 2024 он болон 2025 оны 1 дүгээр улиралд гаалийн байгууллагад мэдүүлсэн валютын мэдээлэлд 2 удаа дүн шинжилгээг хийж Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хороодод хүргүүлж, цаашид холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж, дүн шинжилгээг улирал тутам хийж байх чиглэлийг хүргүүлсэн. Дүн шинжилгээний мэдээллийг гаалийн байгууллагын удирдлагуудад танилцуулж, холбогдох эрх бүхий байгууллагууд [redacted] д [redacted] мэдээллийг хүргүүлсэн. <u>Үр дүн:</u> Дүн шинжилгээний үр дүнд харьяа гаалийн газар, хороодыг оновчтой, шаардлагатай удирдлага арга зүйгээр хангаж ажиллах, шаардлагатай залруулах арга хэмжээг авах боломж бүрдсэн.			
5.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	50%	- "Үндэсний аюулгүй байдлын зөвлөл"-өөс гаргасан зөвлөмжийн эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг заасан хугацаанд хүргүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг заасан хугацаанд хүргүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. - Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх Үндэсний зөвлөлийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг заасан хугацаанд хүргүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.	2025.01.01-2025.06.10	100

				- "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2024 оны төлөвлөгөөний биелэлт, тайлан"-г хүргүүлж 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгуулах саналыг хүргүүлсэн. Мөн "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны дэргэдэх Дэд ажлын хэсэгт гаалийн байгууллагаас орж ажиллах алба хаагчийн нэр холбогдох мэдээлэл болон ажлын хэсгийн 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг хүргүүлж ажилласан. Энэ оны эхний хагас жилийн биелэлтийг хуваарийн дагуу 2025 оны 07 дугаар сарын 10-ны дотор хүргүүлнэ. - Гаалийн байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан тус нэгжийн чиг үүргийн ажил арга хэмжээний эхний хагас жилийн биелэлтийг боловсруулж хүргүүлсэн. - <u>Үр дүн:</u> Бодлогын баримт бичгийн хүрээнд төлөвлөгдсөн тус нэгжийн чиг үүргийн дагуу хэрэгжүүлж буй ажил арга хэмжээний биелэлт хагас жилийн байдлаар бүгд биелсэн үзүүлэлттэй байх ба заасан хугацаанд хүргүүлж ажиллаж байна.			
6.	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	50%	- Мөнгө угаах, хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотойгоор харьяа гаалийн газар, хороодыг цаг тухай бүрд холбогдох хууль тогтоомж (жишээлбэл: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Зөрчлийн тухай, Гаалийн тухай хууль г.м)-ийн дагуу заавар, зөвлөмж, удирдамжаар ханган ажилласан. Үүний хүрээнд хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан [redacted] Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тухай хуулийг зөрчсөн [redacted] даагийн	2025.01.01-2025.06.10	100

				үйлдлийг таслан зогсоож, эзэн холбогдогч болон нотлох баримтын хамт эрх бүхий байгууллагуудад харьяаллын дагуу шилжүүлэн өгсөн. Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг хэлэлцэн тухайн өдрийн хуралдаанаас [REDACTED] дугаартай шийдвэрийг гаргасан. Энэ журмын төслийн 11.10-д Зорчигчийн биедээ авч яваа бэлэн мөнгө (валют)-д хяналт тавихад Гаалийн удирдах төв байгууллагаас баталсан "Зорчигчийн хувийн хэрэгсэний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам"-ыг дагаж мөрдөнө гэснийг үндэслэн энэ төслийн 11.11 дэх заалтад "Дээрх журмын дагуу баталгаажуулсан, гаалийн байгууллагад үлдэх, зорчигчийн гаалийн мэдүүлгийг үндэслэн зорчигчийн биедээ авч яваа валютад ажил үүргийн хуваарийн дагуу хяналт тавьж, шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч тухайн ажлын өдөрт багтаан мэдээллийг өөрийн нэвтрэх эрхээр CAIS системийн Эрсдэлийн удирдлага хэсгийн Бэлэн мөнгөний хяналтын программд бүртгэж оруулна." гэсэн заалтыг нэмэлтээр оруулсан. Дээрх нэмэлт өөрчлөлтийг журамд тусгаснаар гаалийн хяналт, шалгалтын явцад улсын хилээр нэвтрүүлэх бэлэн мөнгө (валют)-ний бүртгэл мэдээллийг сайжруулах, баталгаажуулах, болзошгүй хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, хуульд заасан 15 сая төгрөгөөс доош хэмжээгээр гаальд мэдүүлээгүй олон давтамжтай нэвтэрч буй зорчигчдын хөдөлгөөнд тавих гаалийн хяналт шалгалтыг эрчимжүүлэхэд түлхэц болгох ач холбогдолтой байна.	
--	--	--	--	--	--

7.	Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	50%	Нэгжийн үйл ажиллагаа хэвийн үргэлжлэхэд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, хариу арга хэмжээ авч эрсдэлийн түвшинг бууруулах төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	2025.01.01-2025.06.10	100
8.	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	50%	- Гаалийн захиргаа, дотоод ажлын систем програмын дагуу тус нэгжид 15 үүрэг даалгавар ирсэн ба арга хэмжээний биелэлтийг хугацаанд нь хургуулж ажилласан. ГЕГ-ын даргаас өгсөн чиглэлийн дагуу тус нэгжээс 2025 оны эхний 5 сарын байдлаар хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ, дүн шинжилгээнд үндэслэн хэрэгжүүлсэн шалгалт, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн олон улсын болон бүс нутаг, дотоодын нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн чиглэлийн талаарх танилцуулга мэдээллийг ГЕГ-ын удирдлага болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй гаалийн газар хороодын удирдлагад яаралтай хаалттай мэдээллийг 2025 оны дугаар сарын өдөр ЗТГ-ын хийсэн ба тухайн мэдээллийн бэлтгэл ажлын хүрээнд бүхий танилцуулгыг боловсруулж ажилласан.	2025.01.01-2025.06.10	100
9.	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	84%	50%	Хөдөлмөрийн дотоод журмын дагуу нэгжийн бүх албан хаагч цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид	2025.01.01-2025.06.10	100

				бүртгүүлж, зайлшгүй шаардлагатай гадуур ажиллах тохиолдолд CEEPR-д тухай бүр хүсэлтээ оруулан илгээж хэвшсэн. Тайлант хугацаанд алба хаагчид тасалсан өдөр байхгүй.		
	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт			Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж 2025 оны [redacted] дугаар сарын 1 [redacted] өдрийн байдлаар нийт [redacted] н бичиг ирснийг хүлээн авч шийдвэрлэсэн.		
				<u>Ажлын хэсэг</u> 1. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 09 дүгээр тушаалаар "НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2004 оны 1540 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд стратегийн ач холбогдол бүхий зарим аюултай бараа, бүтээгдэхүүнд тавих хяналтын эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор холбогдох хуулийн төслийг боловсруулж, танилцуулах Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Дэд ажлын хэсэг"-д ГЕГ-ын ХТМУТХ-ийн ГУБ [redacted] ажиллаж байна.		
10.		Хэрэгжилт, гүйцэтгэлээр	80%	50%	2025.01.01-2025.06.10	100
				2. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/75 дугаар тушаалаар "ФАТФ-ын зөвлөмжийн Шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн дагуу Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлын үнэлгээг хийж гүйцэтгэх үүрэг бүхий ажлын		

				хэсэг"-д ГЕГ-ын ХТМУТХ-ийн ГУБ [REDACTED] ажиллаж байна. 3. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2025 оны [REDACTED] дугаар сарын [REDACTED] өдрийн [REDACTED] тоот тушаалаар "Монгол Улсын Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж тайлагнах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, Үндэсний эрсдэлийн үнэлгээг хэрэгжүүлэх дэд ажлын хэсгүүдийг Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргын тушаалаар байгуулагдах дэд ажлын хэсэгт ГЕГ-ын ХТМУТХ-ийн [REDACTED] ажиллаж байна. 4. Монголбанкны СМА-ны дэргэдэх байнгын 5 ажлын хэсгийн нэг болох "Хориг арга хэмжээ авах" ажлын хэсэгт Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн үнэлгээний тайлан, зөвлөмж боловсруулах чиглэлээр туслан ажиллах ажлын хэсэгт ГЕГ-ын ХТМУТХ-ийн ГУБ [REDACTED] ажиллаж байна. 5. Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд ISO 9001:2015 "Чанарын удирдлагын тогтолцоо", ISO 27001:2022 "Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо" стандартыг нэвтрүүлэх ажлын хэсэгт тус нэгжийн ГУБ [REDACTED] орж ажиллахаар нэрийг хургүүлсэн. <u>Бусад ажил, арга хэмжээ</u> 1.Цагдаагийн ерөнхий газрын 2025.03.14-ний өдрийн [REDACTED] дугаартай албан бичгээр Монгол Улсад цэргийн дээд генерал цол олгож эхэлсний 81 жилийн ой, "Монгол генералын өдөр"-ийг	
--	--	--	--	--	--

				тохиолдуулан генерал цолтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах тул тус арга хэмжээнд "Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх бус нутгийн болон дотоодын хамтын ажиллагаа" сэдвээр илтгэл хэлэлцүүлэн оролцохыг хүсэлтийн дагуу 6 хуудас бүхий илтгэл Word файлаар, 16 слайд бүхий илтгэлийг Power point дээр боловсруулан хүргүүлж ЗТГ-ын [REDACTED] ний өдөр тус арга хэмжээнд оролцсон. 2. Монгол Улсын Дотоод хэргийн их сургуулийн 2025.02.26-ны өдрийн 01/327 дугаартай албан бичгээр Тус Их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэн, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар хамтран "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттай тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр "Novotel" зочид буудлын хурлын танхимд зохион байгуулах тул тус арга хэмжээнд "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттай холбоотой өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага, хамтын ажиллагаа" сэдвээр эрдэм шинжилгээний илтгэл бичиж оролцох хүсэлт ирүүлсний дагуу 6 хуудас бүхий илтгэл Word файлаар, 18 слайд бүхий илтгэлийг Power point дээр боловсруулан хүргүүлж ХТМУТХ-ийн-ын [REDACTED] й өдөр тус арга хэмжээнд оролцсон. 3. Монгол Улсын Терроризмтой тэмцэх зөвлөлийн ажлын албанаас 2025 оны [REDACTED] сарын [REDACTED] өдрийн [REDACTED] бичгээр Монгол Улсын "Үй оглноор хөнөөх зэвсэг түгээн дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Терроризмтой тэмцэх зөвлөлийн ажиллах журмын 2.3 дахь хэсгийг удирдлага болгон "Терроризмтой тэмцэх зөвлөл"-ийн хуралдааныг зохион байгуулж хамтарч ажиллахыг хүссэн албан бичиг ирүүлсний дагуу	

хамтран ажиглаж байна.

[illegible]

... / Г. Ганзориг /
(Нэр, зарын үсэг)

2008 06 09.
(Оано)

ХАР ТАМХИ, МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ГАНЗОРИГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		64,3

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Удирдлагын академийн богино хугацааны сургалтад хамрагдах	100	15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:			15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	13
2.	Удирдан зохион байгуулах	12
3.	Асуудал шийдвэрлэх	12
4.	Манлайлах	12
5.	Багаар ажиллах	12
6.	Харилцаа	13
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
6	Мэргэжлийн ур чадвар 1.	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		12

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	64,3
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	12
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	—
Нийт оноо= (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		91,3

Үнэлгээ өгсөн:

Гаалийн ерөнхий газрын дарга

Төсвийн шууд захирагч:

..... (Р.Отгонжаргал)
 2025.06.25 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нэгжийн дарга:

..... (Г.Ганзориг)
 2025.06.28 (огноо)